

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдааны 20 дугаар тэмдэглэлд:

“ХХ.9. “Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. БНЭУ-ын Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай)-ыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан, явц, үр дүнгийн талаар танилцуулж байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Цэрэнноров нарт тус тус даалгав.

2. Засгийн газрын тухай хуулийн 20.5.12-т заасан эрхэлсэн асуудлын хүрээний дагуу газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, бодлогын болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.

3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад зориулан “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д олгох зээлийн санхүүжилтийг ирээдүйд бий болох хөрөнгөөр барьцаалах замаар олгох асуудлыг судлан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Хөгжлийн банкны гүйцэтгэх Б.Батбаяр нарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 26 дугаар тэмдэглэлд:

“ХИХ.10. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн явцын талаарх Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын танилцуулгыг Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:

1. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлыг холбогдох гэрээ, хэлэлцээрийн хүрээнд бууруулах арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт даалгав.

2. Түүхий тос дамжуулах хоолойг нарийвчилсан ТЭЗҮ-ээр тооцоолсон хөрөнгө оруулалтын зардлаас бага өртөгтэйгээр Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хэрэглэгдэж байгаа уламжлалт технологийг ашиглан байгуулах санхүүжилтийн болон техникийн боломжийг судалж, танилцуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт үүрэг болгов.

3. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалт (салбар төмөр зам, автозам, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбай, хашаа)-ын хүрээнд хийгдэх ажлыг батлагдсан ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төсвийн дагуу эхлүүлэхийг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Барилга хот байгуулалтын сайд Х.Баделхан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар нарт зөвшөөрч, уг дэд бүтцийн бүтээн байгуулалтын үйл ажиллагаанд шаардагдах санхүүжилтийг тухай бүр шуурхай шийдвэрлэж байхыг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (М.Баярмагнай)-д даалгав.

4. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазарт даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР